



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/446

Мөрөн сум


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн
хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, Засгийн газрын 2019 оны 185 дугаар тогтоол, Хүнс хөдөө аж ахуйн сайд, Сангийн сайдын хамтарсан 2019 оны А-500/283 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А-143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох сумдын 25,0 мянган га бэлчээрт энгийн механик биологийн аргаар мэрэгчтэй тэмцэх ажлыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 11 сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.
2. Сумдын бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, Үлийн цагаан оготно тэмцэх талбайн хэмжээ, зардлын хэмжээг 2 дугаар хавсралтаар, ажлын гүйцэтгэлд хийх хяналтын зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Дээрх ажлыг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу тооцон зарцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-т зөвшөөрсүгэй.
4. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчид, малчдын бүлэг, хоршоог хамруулж, мэрэгч амьтантай тэмцэх гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах, цаг агаарын саатлаас бусад тохиолдолд ажил саатахгүй байх арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
5. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан хамтран ажиллах үр дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-д даалгасугай.
6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА


П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

6710010042

Аймгийн Засаг даргын 2023 оны 8 дүгээр сарын 23-ны өдрийн АИМ дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭР БҮХИЙ СУМДАД БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Д.Чинзориг-Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн,

Б.Бямбасүрэн-Мал үржлийн албаны дарга,

Л.Бямбасүрэн-Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын ахлах байцаагч,

Б.Тунгалаг-Хяналтын албаны ургамал хамгаалал, хорио цээрийн улсын байцаагч,

Н.Анхбаяр-(Цэцэрлэг сумын засаг дарга)

С.Гончигням-(Цагаан-Уул сумын Засаг дарга)

Б.Азаяа-(Бүрэнтогтох сумын Засаг дарга)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Т.Пүрэвхүү-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

-----ooOoo-----

Аймгийн Засаг даргын 2023 оны 8 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



СУМДЫН ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ
ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

Д/д	Сумын нэр	Мэрэгчтэй тэмцэх шаардлагатай талбайн хэмжээ/мянган га /				Зарцуулах хөрөнгө/мянган төгрөг/		Зарцуулах Зориулалт
		Урьд оны тэмцсэн хийсэн талбай	Сумын санал	Оготно тархсан талбайн хэмжээ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын төлөвлөлт	Улсын төсөв /сая.төг/	Сумын баталсан эх үүсвэр	
2.	Цагаан-Уул	6460	12.0	215.0	7.0	10.08	7,5	Оготно устгалд оролцох хүмүүсийн ажлын хөлс, автомашины шатахууны зардал
3.	Бүрэнтогтох	2500	20.0	35.0	8.0	11.52	10,0	Оготно устгалд оролцох хүмүүсийн ажлын хөлс, автомашины шатахууны зардал
Дүн					25,0	36,0 сая төгрөг	26,0	

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 23-ны өдрийн АНХС дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

ҮЛИЙН ЦАГААН ОГОТНОТОЙ
ТЭМЦЭХ АЖЛЫН ХЯНАЛТЫН ЗАРДАЛ

№	Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэх байгууллага	Албан томилолт, Шатахууны зардал
1.	Гэрээ байгуулах, зөвлөмж зааварчилгаа өгөх, талбайн цэг тогтоох	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ХХААГ, ОБГ,	Тухайн үеийн удирдамжаар
2.	Ажлын явц гүйцэтгэлд хяналт тавих	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ХХААГ, ОБГ	Тухайн үеийн удирдамжаар
Нийт	2 удаа орон нутагт ажиллана. /Шаардлагатай тохиолдолд зарим албан хаагчид дахин ажиллана/		4.000.000 /дөрвөн сая төгрөг/